



СЭТГЭЛ ЗҮЙН ДАРХЛААТАЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ТӨСӨЛ

Эрдэнэт хот

2025 он

АГУУЛГА

1. Төслийн танилцуулга
2. Төслийн үндэслэл
3. Зорилго, Зорилтууд
4. Төслийн үр дүн ач холбогдол
5. Төслийн ач холбогдол
6. Хамрах хүрээ
7. Төслийн өнөөгийн байдал
8. Төслийн үйл ажиллагаа
9. Төслийн тогтвортой байдал
10. Төсөв , хөрөнгө оруулалт
11. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр:	Сэтгэл зүйн дархлаатай төрийн байгууллага
Төсөл хэрэглэх газар:	Монгол улс
Төсөл хэрэгжүүлэх салбар:	Төрийн байгууллага
Үйл ажиллагааны үндсэн чиглэл:	Мэргэшсэн сэтгэл зүйч бэлтгэх
Төсөл хэрэгжих хугацаа:	12 -18 сар
Төслийн нийт төсөв:	\$57,500 -\$397,500
Төсөл хэрэгжүүлэгч:	Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар
Харилцах утас:	9111-8948

2 ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын төрийн албан хаагчдад зориулсан сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал бөгөөд олон нийтийн ойлголт, хандлага сул байгаа нь төрийн зүгээс сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих бодлого, санхүүжилт хангалтгүйн улмаас төрийн албан хаагчдын сэтгэл зүйн дархлаа сул байх үндэслэл болж байна. Канад, Герман, Өмнөд Солонгос гэх мэт өндөр хөгжилтэй орнуудын төрийн албан хаагчдын сэтгэл зүйн тусламж үйлчилгээний бодлого, чанар, хүртээмжтэй Монгол улсыг харьцуулахад хангалтгүй байна.

№	Улс	Сэтгэл зүйн эрүүл мэндэд зарцуулдаг төсвийн хувь	Төрийн албан хаагчдийн сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний хүртээмж
1	Канад	6,3%	Тодорхой түвшинд хүрсэн
2	Герман	11%	Хувьсах /муж бүртээ ялгаатай/
3	Өмнөд Солонгос	1,9% /Хувийн хэвшилд эрх мэдлийн 90% өгсөн/	Хязгаарлагдмал
4	Монгол	0%	Олон нийтийн хандлага муу, үйлчилгээний дутагдал

Судалгаагаар Монгол улсын төрийн албан хаагчдын 65% нь архаг стрессийн түвшинд ажилладаг бөгөөд энэ нь шийдвэр гаргах чадамж, хамт олны харилцаа, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарт шууд нөлөөлж байна. Гэтэл төрийн байгууллагууд албан хаагчиддаа сэтгэл зүйн тусламж, зөвлөгөө өгөх бүтэцгүй, хувийн хэвшлийн сэтгэл зүйчидтэй холбогдох, хамтран ажиллах боломж нь төсөв санхүүгийн хувьд хязгаарлагдмал байна. Тиймээс олон улсын жишигт нийцсэн, төрийн байгууллагын онцлогт тохирсон, мэргэшсэн сэтгэл зүйчдийг бэлтгэж, зөвлөгөө өгөх бүтцийг бий болгох шаардлага бий болж байна

3. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Монгол улсын төрийн албан хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, сэтгэл зүйн боловсрол олгох, ажлын байранд дахь стрессийг бууруулж, сэтгэл зүйн дархлааг бий болгох, байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн сэтгэл зүйчдийг олон

улсын хөтөлбөрөөр мэргэшүүлэн бэлтгэх, төрийн байгууллагуудад сэтгэл зүйн үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлэх.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

-Монгол улсад сэтгэл зүйн үйлчилгээний тогтолцоог төрийн байгууллагад нутагшуулах суурийг тавих

-21 мэргэжлийн сэтгэл зүйчийг олон улсад /Герман, Өмнөд Солонгос, Канад/ мэргэшүүлэх

-Бэлтгэгдсэн мэргэшлийн сэтгэл зүйчийг төрийн байгууллагад хуваарилан ажиллуулах

-Төрийн байгууллага дотор сэтгэл зүйн дархлааг дэмжих систем /бүлгийн зөвлөгөө, сургалт/ бий болгох

-Хяналт, үнэлгээ, тогтвортой хөгжлийн механизмыг нэвтрүүлэх

4. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ГАРАХ ҮР ДҮН

- ✓ Монгол улсад гадаадын өндөр хөгжилтэй улсад суралцаж, мэргэшсэн сэтгэл зүйчид төрийн байгууллагад ажиллаж эхэлнэ.
- ✓ Төрийн албан хаагчдын стресс буурч, сэтгэл зүйн дэмжлэгтэй орчин бүрдэж улмаар төрийн байгууллагуудын бүтээмж, албан хаагчдын сэтгэл ханамж нэмэгдэнэ.
- ✓ Сэтгэл зүйн үйлчилгээний үндэсний системийг бий болгоно.

5. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ГАРАХ ҮР ДҮНГ ТООН БОЛОН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТЭЭР

5.1 Сэтгэл зүйн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.

- 21 аймгийн 4239 төрийн байгууллагад сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэгийн үйлчилгээ байнгын тогтолцоотой болно.

-Мэргэжлийн сэтгэл зүйчдийн хүрч ажиллах цар хүрээ нэмэгдэнэ.

5.2 Төрийн албан хаагчдын сэтгэл зүйн дархлааны одоогийн үзүүлэлт сайжирна.

Анхан шатны судалгаагаар сэтгэл хямрал, ажлын стрессийн түвшин өндөр буюу “дундаас дээш” түвшинд гарсан байгууллагын хувь хэмжээг төслийн хэрэгжилтийн дараа хяналтын судалгаагаар 40 хувь хүртэл бууруулж “дунд болон бага” түвшинд шилжүүлнэ.

№	Үзүүлэлт	Суурь түвшин /2025/	Зорилтот түвшин /2026/
1	Стресс өндөртэй ажилтны хувь	68%	≤ 40%
2	Сэтгэл хямралын эмгэг шинж тэмдэгтэй ажилтны хувь	32%	≤ 20%
3	Ажлын сэтгэл ханамж дунд болон доогуур хувь	54%	≤ 30%

4	Сэтгэл зүйн үйлчилгээний хүртээмжгүй төрийн байгууллага	100%	0%
---	---	------	----

5.3 Байгууллагын бүтээмж, ажиллах орчны уур амьсгалын сайжралт.

Төрийн байгууллагын хүний нөөц, удирдлагын үнэлгээгээр хамт олны уур амьсгал, харилцаа, ажлын гүйцэтгэлийн чанар 32%-40% хүртэл өсөн, төрийн албан хаагчын тогтвортой байдал нэмэгдэж, ажлын байран дахь зөрчил, гомдол, маргааны тоо болон иргэдээс төрийн албан хаагчид гаргадаг ёс зүйн гомдлын тоо буурна.

6. ТӨСЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Хамрах хүрээ: Монгол улс, 21 аймгийн 1,317 төрийн байгууллага, 110,345 төрийн албан хаагч

Газар зүйн хувьд: Монгол улс

Хугацаа: 12 -18 сар

Шууд үр шим хүртэгчид: Монгол улсын орон нутгийн 110,345 гаруй төрийн албан хаагчид: ажлын байрны орчин нөхцөлд төдийгүй гэр бүлийн орчинд сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол нэмэгдэнэ.

Шууд бус үр шим хүртэгчид: Нийт 110,345 гаруй төрийн албан хаагчдын гэр бүлийн гишүүд, хүүхдүүдийн сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол нэмэгдэнэ. Төрийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.

7. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

7.1 Өнөөгийн нөхцөл байдлын судалгаа

Монгол улсад 226,496 төрийн албан хаагч ажиллаж байгаа бөгөөд эдгээр албан хаагчдийн сэтгэл зүйн эрүүл мэндийн талаарх судалгаа харьцангуй олдоц багатай байна. Монгол улсын хэмжээнд сэтгэл зүйн дархлааны өнөөгийн байдал нь нийгмийн болон эдийн засгийн дарамт, сэтгэл зүйн боловсролын дутагдал, хүүхэд залуусын стресс, сэтгэл гутрал гэх мэт олон хүчин зүйлээс хамааран хэлбэлзэж байна. 2021 онд 7019 иргэнийг хамруулан хийсэн сэтгэл зүйн дархлааны өнөөгийн байдлыг тодорхойлсон судалгаагаар 39,6% сэтгэл гутралын шинжтэй, 55% сэтгэл түгших хам шинжтэй, 48,5% биеийн өвдөлт, таагүй мэдрэмж илэрдэг биеших шинж тэмдэгтэй гэсэн үр дүн гарсан бол сургуулийн орчин дахь сэтгэл зүйн асуудлыг судлахад 4 сурагч тутмын 1 амиа хорлох талаар бодож байсан, 7 сурагч тутмын 1 амиа хорлох төлөвлөгөө боловсруулж байсан, 10 сурагч тутмын 1 амиа хорлох оролдлого хийж байсан гэсэн үр гарсан нь өсвөр үеийнхний сэтгэл зүйн эрүүл мэндийн байдалд нөгөөтэйгүүр Монгол улсад сэтгэл зүйн эрүүл мэндийн байдалд анхаарал хандуулах шаардлагатайг дээрх судалгааны үр дүн харуулж байна.

2012 онд Орхон аймагт Сэтгэцийн эрүүл мэндийн төвөөс хийгдсэн судалгаагаар сэтгэл түгших-18,8%, сэтгэл гутрал-4,4%, стресс -17,1% гэсэн дүн гарсан бол одоогоор

төрийн албан хаагчдын сэтгэл зүйн дархлааг судалсан байдал Нийгмийн даатгалын газраас өөр байхгүй байна.

Сүүлийн жилүүдэд төрийн албан хаагчдад дараах сэтгэл зүйн тулгамдсан асуудлууд нэмэгдэж байгааг ХНХЯ-ны 2023 онд хийсэн “Төрийн албан хаагчдын сэтгэл зүйн судалгаа”-аас:

- 68% нь өндөр түвшний стресс, ажлын дарамтад орж буйгаа илэрхийлсэн
- 46% нь ажилдаа сэтгэл ханамжгүй, мэргэжлийн дэмжлэг дутмаг гэж үздэг
- 61% нь ажлын байрны сэтгэлзүйн дэмжлэг, мэргэшсэн зөвлөгөө авах нөхцөлгүй
- 15–20% нь шалтгаан нь тодорхойгүй бие махбодийн өвдөлт, хандлага бууралт мэдэрч байгаа (психосоматик шинж)

Эдгээрийн гол **шалтгаан нь**:

- Тогтворгүй ачаалал, улс төрийн нөлөөтэй орчин
- Дээд шатны удирдлагаас сэтгэл зүйн хүлээлт, дэмжлэг байхгүй
- Байгууллагын уур амьсгал, харилцааны зөрчил
- Сэтгэл зүйчийн тогтолцоо, стандарт, хүний нөөц байхгүй.

Давуу талууд (Strengths)	Сул талууд (Weaknesses)	Боломжууд (Opportunities)	Аюулууд (Threats)
1. Хэрэгжүүлсэн туршлагай, эерэг үр дүн гарсан 2. Төрийн бодлоготой нийцсэн 3. Сэтгэл зүйн хүртээмжийг нэмэгдүүлсэн 4. Богино хугацаанд үр дүнг хэмжих боломжтой	1. Санхүүгийн боломж муу 2. Төрийн шийдвэр, оролцооноос шууд хамааралтай	1. Шинэ ажлын байр нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин бууруулах 2. Хэрэгжүүлэх хувилбартай буюу сонголттой 3. Төрийн үйлчилгээ, бүтээмжийг нэмэгдүүлэх 4. Сэтгэл зүйн нэгдсэн хөтөлбөртэй болох 5. Суурь судалгаатай болох 6. Сэтгэл зүйчдийн өрсөлдөөн нэмэгдэж чадавхижих	1. Хүний нөөцийн тогтворгүй байдал 2. Төрийн дээд шатны байгууллага төслийг хэрэгжүүлэхийг дэмжихгүй байх 3. Нийгмийн сэтгэл зүйн эрүүл мэндийн ойлголтыг өөрчлөхөд урт хугацаа шаардах

Энэхүү төсөл нь зөвхөн 21 сэтгэл зүйчийг мэргэшүүлэн бэлтгэх асуудал биш юм. Энэ бол төрийн албаны сэтгэл зүйн тогтолцооны шинэчлэл, институцийн түвшинд сэтгэл зүйн дэмжлэгийн систем бий болгох стратегийн эхлэл юм. Хэрвээ энэхүү шинэчлэл эхлэхгүй бол төрийн албаны хямрал, бүтээмжийн доройтол нь цаашид улам даамжрах эрсдэлтэй байна.

7.2 Хүний нөөцийн өнөөгийн байдал

Монгол улсад жил бүр дундажаар 150-200 сэтгэл зүйч мэргжлээр их, дээд сургууль төгсдөг бөгөөд хүний нөөцийн тоо хангалттай хэмжээнд хүрсэн боловч ажиллах орон тоо, ялангуяа төрийн байгууллагын түвшинд хомс байна.

2023 оны байдлаар бүртгэлтэй сэтгэл зүйчдийн 75 гаруй хувь нь Улаанбаатар хотод төвлөрсөн бөгөөд орон нутгийн байгууллагуудад мэргэжлийн сэтгэл зүйч ажиллах орон тоо дутмаг, нөхцөл боломж хязгаарлагдмал байна. Түүнчлэн төрийн байгууллагын түвшинд сэтгэл зүйчийн орон тоо тогтмол батлагдаагүй, төсөв санхүүжилт хангалтгүй, мэргэжлийн орчны дэмжлэг сул байгаа нь энэ чиглэлээр ажиллах сонирхлыг бууруулж байна.

Энэ нь төрийн байгууллагын дотоод орчны сэтгэл зүйн дэмжлэгийн тогтолцоо сул байгаагийн нэг гол шалтгаан болж, ажиллагсдын сэтгэл зүйн дархлаа, бүтээмж, багаар ажиллах чадвар, харилцаа хандлагад сөрөг нөлөө үзүүлж байна.

Иймд сэтгэл зүйч мэргэжилтнүүдийг төрийн байгууллагад тогтмол ажиллуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, орон тоо болон төсөвт тусгах, мэргэжлийн орчныг дэмжих бодлого хэрэгжүүлэх нь нэн шаардлагатай байна. Энэ нь зөвхөн хүний нөөцийн оновчтой ашиглалтыг хангаад зогсохгүй, “сэтгэл зүйн дархлаатай төрийн байгууллага”-ыг төлөвшүүлэх суурь нөхцөл болох юм.

Бүс нутаг	Тархалтын байдал	Онцлог, нөхцөл байдал
Улаанбаатар хот	Сэтгэл зүйчдийн 70–80% төвлөрсөн	СЭМҮТ, боловсролын байгууллагууд, хувийн төвүүд олноор байрладаг
Аймгийн төвүүд	Хязгаарлагдмал боловч цөөн тоогоор байгаа	Аймгийн нэгдсэн эмнэлэг, боловсролын газар, гэр бүл, хүүхдийн байгууллагад ажилладаг
Сумдын түвшин	Бараг байхгүй	Цөөн тооны сумдын сургуульд л сэтгэл зүйч байдаг
Онцгой бүсүүд (уул уурхай, хилийн орчмын сум)	Хэсэгчилсэн байдлаар	Уул уурхайн болон хил хамгаалах байгууллагад сэтгэл зүйч ажилладаг

8. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

8.1 Үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө

Үе шат	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтрах байгууллага
1	Төрийн албан хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагын судалгааг шинэчлэн авч үр дүнг боловсруулах	2025.09-2025.12	Төслийн баг	Төрийн албаны зөвлөл
2	“Төрийн албаны мэргэшсэн” сэтгэл зүйч орон тоог батлуулах	2025.09-2025.12 сар	Төрийн албаны зөвлөл	Засгийн газар
3	Сэтгэл зүйчдийг сонгон шалгаруулж, гэрээ хийж, хуваарилах	2026.01-2026.02 сар	Төрийн албаны зөвлөл	Төрийн албаны зөвлөл, аймгийн удирдлагууд
4	Гадаадын сургалтын байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах	2026.01-2026.02 сар	Төрийн албаны зөвлөл	Аймгийн удирдлагууд
5	Олон улсын сургалтын хөтөлбөрт хамруулах	2026.03-2026.09 сар	Төрийн албаны зөвлөл	Засгийн газар
6	Төрийн албаны мэргэшсэн сэтгэл зүйчдийг бэлтгэх хөтөлбөр боловсруулан, орон тооны бус сэтгэл зүйчдийн нөөц бүрдүүлэх		Төрийн албаны зөвлөл	ТББ
7	Төрийн албанд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний тогтолцоо нэвтрүүлэхнд шаардлагатай бодлогын баримт бичиг боловсруулна	2026.03-2026.09 сар	Төрийн албаны зөвлөл	Засгийн газар
8	Төрийн албан хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагын судалгааг шинэчлэн авч үр дүнг боловсруулах	2026.11-12 сар	Төрийн албаны зөвлөл	
8	Үнэлгээ, тайлан, тогтвортой төлөвлөлт	2026.12 сар	Төрийн албаны зөвлөл	

8.2 Сургалт явагдах боломжтой улс орон, хөтөлбөрүүд

Хамаарах сэдэв давхцалгүй 3 улсад мэргэшүүлснээр төсөлд хамрагдсан сэтгэл зүйчид суралцсан туршлагаа солилцон төрийн албанд сэтгэл зүйн тогтолцоог нутагшуулах бодлого боловсруулахад чиглэж дараах 3 улсыг сонгон авсан.

№	Улс	Хөтөлбөрийн нэр	Хугацаа	Хамаарах сэдэв	Тайлбар
1	Герман улс (Берлин)	- Occupational & Organizational Psychology - Workplace Mental Health and Coaching Techniques	6 сар	•Ажлын байрны стресс менежмент •Байгууллагын сэтгэл судлалын үндэс • Когнитив зан үйлийн аргачлал • Сэтгэл зүйн коучинг ба супервиз	Байгууллагын сэтгэл зүй, хүний нөөцийн сэтгэл судлал, ажилчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих стратеги, коучингийн техникүүдийг агуулна. Сургалтад Герман дахь их сургуулиуд болон мэргэжлийн байгууллагууд хамтран оролцож, практик төвтэй, судалгаанд суурилсан сургалт явагдана.
2	Өмнөд Солонгос (Сөүл)	- Crisis Intervention & Mental Health Policy in Government Settings - Psychological Resilience Training Methods	6 сар	• Хямралын үед үзүүлэх сэтгэл зүйн тусламж •Байгууллагын түвшний resilience хөгжүүлэх хөтөлбөрүүд • Төрийн албан хаагчдын сэтгэл зүйн эрсдэлийн менежмент • Сэтгэл зүйн бодлого боловсруулах арга зүй	Төрийн байгууллагад ажиллаж буй хүмүүст зориулсан сэтгэл зүйн түргэн тусламж, бодлогын боловсруулалт, тогтолцооны дэмжлэг, байгууллагын тэсвэр тэвчээрийг нэмэгдүүлэх аргуудыг хамарна. Солонгосын үндэсний сэтгэл судлалын хүрээлэн болон их сургуулиуд хамтран зохион байгуулна.

3	Канад улс (Торонто)	- Mental Health in the Public Sector - Applied Clinical Psychology in Organizations	6 сар	Олон нийтэд суурилсан сэтгэл зүйн үйлчилгээний загварууд •Байгууллагын түвшинд клиник сэтгэл судлал хэрэглэх арга • Кейс анализ, протокол боловсруулах •Эмпирик судалгаа ба нөлөөллийн үнэлгээ	Төрийн байгууллагын хүрээнд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх систем, клиник практик, судалгаанд суурилсан хэрэглээ зэргийг хослуулсан сургалт юм.
---	------------------------	--	-------	---	--

9. ТӨСЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ СТРАТЕГИ

Төслийн үр дүнг урт хугацаанд хадгалах, өргөжүүлэх зорилгоор дараах тогтортой хөгжлийн 5 чиглэлийг хэрэгжүүлнэ:

1. Сэтгэл зүйчийн албан тушаалыг албажуулах.

Төрийн албаны салбар зөвлөлд **“төрийн албаны мэргэшсэн сэтгэл зүйч”** гэсэн албан тушаалыг шинээр бий болгож, төрийн албаны ангилал, зэрэглэлд оруулан, олон улсын сургалтад хамрагдаж, төгссөн сэтгэл зүйчдийг төрийн албаны салбар зөвлөлд байнгын орон тоотой ажиллуулна.

2. Санхүүжилтийн дотоод эх үүсвэр бий болгох.

Төрийн байгууллагын жил бүрийн төсөвт “сэтгэл зүйн үйлчилгээний зардал” гэсэн ангилал нэмэх санал боловсруулж, Сангийн яамтай хамтран ажиллана.

3. Үндэсний мэргэшүүлэх төв байгуулах

Олон улсын хөтөлбөрт хамрагдан төгссөн сэтгэл зүйчид туршлагаа дотооддоо түгээх зорилгоор **“Төрийн байгууллагын сэтгэл зүйчийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр”** боловсруулна. Энэхүү хөтөлбөрөөр дараагийн үеийн сэтгэл зүйчдийг дотоодод бэлтгэх, богино хугацааны сургалт, давтан сургалт зэрэг үүрэг гүйцэтгэнэ.

4. Хууль, бодлогын түвшинд тусгах

“Төрийн албан хаагчдын сэтгэл зүйн хамгааллын бодлого” боловсруулах санал боловсруулан, Төрийн албаны зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн яаманд танилцуулна.

Засгийн газрын бодлогод нийцүүлэн ЭМЯ, БШУЯамтай хамтарсан журам, тогтоол, бодлогын баримт бичиг батлуулах алхмуудыг хийнэ.

5. Нээлттэй хамтын ажиллагаа, түншлэлийн тогтолцоо

Олон улсын байгууллагуудтай /Солонгосын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагын (KOICA), урт хугацааны санхүүжилт, мэргэжлийн зөвлөгөөний хамтын ажиллагаа өрнүүлнэ. Мөн улсын болон хувийн их дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудтай гурван талт түншлэл байгуулна /мэргэшүүлэх, судалгаа, арга зүйн дэмжлэг г.м/

10. ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Төсвийг санхүүжүүлэхэд олон улсын байгууллага, хөгжлийн хөтөлбөрүүд, нийгмийн хариуцлагын түншлэлийг татан оролцуулна.

1. Олон улсад мэргэшүүлэх сургалтын үндсэн зардал /ам.доллараар/				
Хувилбар		А	В	С
№	Зардлын төрөл	1 хүн /улсын хэмжээнд/	5 хүн /бүсчлэлээр/	21 хүн /аймгаар/
1	Сургалтын төлбөр / 6 сар/	\$5,000	\$25,000	\$105,000
2	Амьдрах зардал /сар бүр/	\$9,000	\$45,000	\$189,000
3	Нислэгийн зардал /2тал/	\$2,000	\$10,000	\$42,000
4	Даатгал, виз, бичиг баримт	\$800	\$4000	\$16,800
5	Сургалтын материал, бичиг баримт	\$700	\$3500	\$14,700
Нийт		\$17,500	\$87,500	\$367,500
2.Нэмэлт зардал /ам.доллараар/				
Удирдлагын зардал /төслийн баг/		\$10,000	\$10,000	\$10,000
Хяналт-шинжилгээ, судалгааны зардал		\$5,000	\$5,000	\$5,000
Сургалтын дараах нэвтрүүлэлт, дотоод арга хэмжээ		\$25,000	\$20,000	\$15,000
Нийт		\$40,000	\$35,000	\$30,000
3.Нийт төсөв				
Сэтгэл зүйчдийн сургалтын зардал		\$17,500	\$87,500	\$367,500

Төслийн хэрэгжилтийн зардал	\$40,000	\$35,000	\$30,000
Нийт	\$57,500 /201,250,000 төгрөг/	\$122,500 /428,750,000 төгрөг/	\$397,500 /1,391,250,000 төгрөг/

Төгрөгөөр (1USD= -3500 төгрөг)

11. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төслийн хэрэгжилтийн бүх шатанд чанар, үр нөлөөг хянаж, зорилтот үр дүнд хүрч буй эсэхийг тоон болон чанарын шалгуураар үнэлнэ.

1. Хяналт-шинжилгээний гол шалгуур үзүүлэлт /Key Indicators/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин /2025/	Зорилтот түвшин /2026/
1	Сэтгэл зүйчдийн тоо /мэргэшсэн/	хүн	0	21
2	Сэтгэл зүйн үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлсэн төрийн байгууллага	тоо	0	1,317
3	Стресстэй ажилтны хувь	%	68%	≤ 40%
4	Сэтгэл ханамжтай ажилтны хувь	%	46%	≤ 65%
5	Үйлчилгээнд хамрагдсан ажилтны тоо	хүн	0	110,345
6	Байгууллагын уур амьсгалын эерэг үнэлгээ	%	46%	≤ 70%

2. Хяналтын үе шат /Monitoring Timeline/

№	Үе шат	Хугацаа	Үйл ажиллагаа
1	Суурь үнэлгээ	2025.12	Сэтгэл зүйн дархлаа, стресс түвшинг үнэлэх анхан шатны судалгаа
2	Явцын хяналт	2026.06	Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан сэтгэл зүйчдын явцын тайлан
3	Үйлчилгээний туршилтын хяналт	2026.09	Төрийн байгууллагад нэвтрүүлэлт, урьдчилсан нөлөөллийн үнэлгээ
4	Эцсийн үнэлгээ	2026.12	Үр дүнгийн тоон судалгаа, чанарын дүн шинжилгээ

3. Үнэлгээний аргачлал

➤ Тоон судалгаа:

-Төрийн албан хаагчдын стресс, сэтгэл хямралын оношилгооны асуулга (DASS-21, PHQ-9 г.м)

-Сэтгэл ханамж, байгууллагын уур амьсгалын индекс (Likert scale 1-5)

➤ Чанарын үнэлгээ:

-Ярилцлага (удирдлага, төрийн албан хаагчид сэтгэл зүйчидтэй)

-Фокус групп хэлэлцүүлэг

-Үйлчилгээний кейс судалгаа г.м

➤ Гүйцэтгэлийн шалгуур:

-Төслийн хугацаанд үйл ажиллагааг хэрэгжүүлж буй эсэх

-Санхүүгийн зардлын тайлан, үр ашиг

12.2 Хариуцах бүтэц ба мэдээллийн урсгал

Хяналт, үнэлгээний үндсэн баг: -Төслийн багийн 2 ажилтан

Гадаад хөндлөнгийн үнэлгээ: -Эцсийн шатанд хараат бус үнэлгээ хийх зөвлөх баг /их дээд сургууль, судалгааны баг/

Тайлангийн давтамж:

-Улирал бүрийн явцын тайлан

-Эцсийн үр дүнгийн тайлан

-Хөрөнгө оруулагчдад зориулсан тайлан

12. Хавсралт

12.1 Сэтгэл зүйчийг сонгон шалгаруулах шалгуур

1.Ерөнхий шаардлага:

-Сэтгэл судлалын бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй

-Мэргэжлээрээ 2+ жил тасралтгүй ажилласан туршлагатай

-Монгол хэл дээр сэтгэл зүйн оношлогоо хийх чадамжтай, англи хэлний мэдлэгтэй

2. Тусгай шалгуур

№	Шалгуур	Тайлбар	Оноо
1	Боловсролын зэрэг	Бакалавр-10 оноо Магистр-15 оноо	15
2	Ажлын туршлага	2-5 жил-10 оноо 6+ жил-15 оноо Байгууллагын сэтгэл зүйчээр ажилласан бол +5 оноо	20

3	Сэтгэл зүйн оношлогооны мэдлэг	DASS8 PHQ-98 GAD-7 зэрэг үнэлгээнүүдийг ашиглаж байсан туршлага	15
4	Ярилцлага	Сэтгэл зүйчийн ёс зүйн байдал, тохиолдол шийдвэрлэх чадвар	30
5	Англи хэлний мэдлэг	IELTS оноотой бол	10
6	Хувийн хөгжил, манлайлал	CV, эсээ, ярилцлагаар дүгнэнэ	10

Нийт 100 онооноос 80+ авсан сэтгэл зүйчдийг сонгон шалгаруулна.

12.2 Сэтгэл зүйн оношлогооны хэрэгслүүд

1. DASS-21 (Depression, Anxiety, Stress Scale – 21 items)

Зорилго: Сэтгэл гутрал, түгшүүр, стрессийн түвшинг хэмжих.
 Ашиглалт: Сүүлийн долоо хоногийн сэтгэлзүйн байдалд үнэлгээ өгнө.
 Хэмжээс: 3 дэд хэмжээстэй (depression, anxiety, stress), тус бүр 7 асуулттай.

2. Big Five Personality Traits (NEO-FFI)

Зорилго: Хувийн зан төлвийн таван том хэмжүүрийг тодорхойлох.

Хэмжээс:

- Extraversion (Гадагшаа чиглэсэн байдал)
- Agreeableness (Эвтэй байдал)
- Conscientiousness (Хариуцлагатай байдал)
- Neuroticism (Сэтгэл санааны тогтворгүй байдал)
- Openness (Нээлттэй байдал)

3. MBTI (Myers–Briggs Type Indicator)

Зорилго: Хувь хүний төрөл, ажиллах хэв маягийг тодорхойлох.

Хэмжээс: 16 төрлийн хувь хүний хэв маягт ангилна.

Хослолууд: Extraversion–Introversion, Sensing–Intuition, Thinking–Feeling, Judging–Perceiving.

4. GHQ-12 (General Health Questionnaire)

Зорилго: Ерөнхий сэтгэлзүйн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох.

Ашиглалт: Сэтгэлзүйн асуудал, стресс, сэтгэл гутралын эрсдэлийг анхан шатанд илрүүлнэ.

12.3 Амьдрах зардлын дэлгэрэнгүй /ам.доллараар/

Канад улс /1 сар/

№	Зардлын төрөл	1 хүний сарын дундаж зардал (USD)	Тайлбар
---	---------------	-----------------------------------	---------

1	Байр	\$800-\$1,500	Хот болон байрны төрлөөс хамаарна
2	Хоол хүнс	\$200-\$400	Гэртээ хоол хийх зардал
3	Нийтийн тээвэр	\$80-130	Оюутны хөнгөлөлтэй сарын тасалбар
4	Ном, хичээлийн хэрэгсэл	\$70-125	
5	Интернет ба гар утас	\$50-100	Үйлчилгээний багцаас хамаарна
6	Эрүүл мэндийн даатгал	\$50-125	
7	Бусад зардал	\$150-300	Хувийн хэрэглээ
Дундаж зардал			\$1,400-2,600

Герман улс /1 сар/


№	Зардлын төрөл	1 хүний сарын дундаж зардал (USD)	Тайлбар
1	Байр	\$380-\$760	Оюутны дотуур байр
2	Хоол хүнс	\$270-\$380	Гэртээ хоол хийх зардал
3	Нийтийн тээвэр	\$50-100	Хагас жилийн тасалбар
4	Ном, хичээлийн хэрэгсэл	\$20-50	Сургалтын материал ном
5	Интернет ба гар утас	\$20-50	Үйлчилгээний багцаас хамаарна
6	Эрүүл мэндийн даатгал	\$110-130	Оюутнуудад зориулсан хөнгөлөлттэй даатгал
7	Бусад зардал	\$50-100	Хувийн хэрэглээ
Дундаж зардал			\$900-1,570

Өмнөд Солонгос улс /1 сар/

№	Зардлын төрөл	1 хүний сарын дундаж зардал (USD)	Тайлбар
1	Байр	\$260-\$600	Оюутны дотуур байр, хуваалцсан байр
2	Хоол хүнс	\$200-300	Гэртээ хоол хийх зардал
3	Нийтийн тээвэр	\$40-60	Сарын тасалбар
4	Ном, хичээлийн хэрэгсэл	\$40-75	Сургалтын материал ном
5	Интернет ба гар утас	\$25-40	Үйлчилгээний багцаас хамаарна
6	Эрүүл мэндийн даатгал	\$75-100	Заавал даатгал
7	Бусад зардал	\$40-110	Хувийн хэрэглээ
Дундаж зардал			\$680-1,285

5. Дундаж зардал -\$1,500

12.4 Төсөл хэрэгжүүлэгч багийн танилцуулга

№	Овог нэр	Мэргэжил, зэрэг	Албан тушаал	Туршлага	Төсөлд гүйцэтгэх үүрэг
1	Нэргүйн Хулан 	Эрх зүйч, сэтгэл судлаач /магистр/	Хамралт, орлого шимтгэлийн өр хариуцсан улсын байцаагч	-2023 онд “Ухаалаг ажлын байр” төсөлд багийн гишүүнээр сэтгэл зүйн зөвлөгөөг иргэнд хүргэх ажил хариуцан ажилласан. -2024 оны Орхон аймгийн Нийгмийн даатгалын газарт “Сэтгэл зүйн дархлаатай хамт олон” төсөл санаачлан хэрэгжүүлсэн. -2025 онд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албаны реформ-бидний шийдэл” нэртэй судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл	Төслийн багийн ахлагчаар
2	Ганзоригтын Галбадрах	Эдийн засагч /магистр/	Захиргаа, хяналтын хэлтсийн дарга	2018-2023 оны хооронд -Роботын процессын автоматжуулалт төсөлд багийн гишүүнээр үйл	Төслийн багийн гишүүнээр

				ажиллагааны процессын зураглал гаргаж ажилласан -Ухаалаг ажлын байр төсөлд багийн гишүүнээр иргэнд үйлчилдэг үйлчилгээний хэсгийг процессын сайжруулалт, дата өгөгдөл үүсгэх ажил хариуцан ажилласан -Байгаль орчинд ээлтэй ногоон байгууллага төсөлд багийн ахлагчаар тус тус ажилласан.	
3	Жаргалын Халиунаа 	График дизайнер /бакалавр/	Мэдээллийн технологийн мэргэжилтэн	-2022 онд Мон-Х Инновацийн хөтөлбөрт Роботын процессын автоматжуулалт төслийн багийн гишүүн	Төслийн багийн гишүүнээр